Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 9 дүгээр хавсралт “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ” /2020.01.01-нээс мөрдөж эхэлсэн/

- Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол *“Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол *“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”*
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол *“Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”*
- Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоол *“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай”*
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол *“Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”*
- ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоол *“Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай”*
- ТӨБЗГ-ын 2020 оны 50 дугаар тогтоол *“Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- ТӨБЗГ-ын 2020 оны 51 дүгээр тогтоол *“Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай”*
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн *“Жишиг норм батлах тухай”* 390 дугаар тушаал *“Автомашин 100 км гүйлтийг зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”*

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

МОНЦАМЭ агентлаг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

МОНЦАМЭ агентлагийн даргын 2012 оны 32 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталж, Дотоод хяналт шалгалтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын баг нь тайлант онд хяналт шалгалтын тусгайлсан төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

МОНЦАМЭ агентлагийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг үндэслэн 1.834,382.7 мянган төгрөгөөс 2



МОНЦАМЭ агентлагийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хувиар буюу 36,687.7 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

МОНЦАМЭ агентлагийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 195,249.6 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	68,719.7	28,340.4	(40,379.3)
Урьдчилгаа (урьдчилж гарсан зарал)	30,000.0	-	(30,000.0)
Бараа материал	42,188.7	68,863.0	26,674.3
Үндсэн хөрөнгө	653,084.4	892,039.1	238,954.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>793,992.8</b>	<b>989,242.5</b>	<b>195,249.7</b>
Өр төлбөр	509.4	654.0	144.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	793,483.4	988,588.5	195,105.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн</b>	<b>793,992.8</b>	<b>989,242.5</b>	<b>195,249.7</b>

Авлага дансны үлдэгдэл 28,340.3 мянган төгрөг болж 40,379.3 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлагын тооцоог барагдуулснаас шалтгаалжээ. Тус дансны үлдэгдэлд 2020 онд үүссэн 28,132.4 мянган төгрөгийн байгууллагаас, 208.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 68,863.0 мянган төгрөг болж 26,674.3 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хэвлэл захиалгын тоо буурч, улмаар бичиг хэргийн материалын зарцуулалт багассан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 892,039.1 мянган төгрөг болж 238,954.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 287,326.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, нэмэлт төсвийн хөрөнгөөр 77,950.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авч, 24,932.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 102,460.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан нь шалтгаалжээ.

Тайлант онд ТӨБЗГ-ын 663 дугаар тогтоолоор 170,334.5 мянган төгрөгийн балансын үнэтэй, 150,462.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 19,872.4 мянган төгрөгийн үлдэх өртөг бүхий Ландкрузер 200 маркийн автомашиныг Засгийн газрын автобазаас балансад шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын А-1/911 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу 93 нэрийн 102,460.1 мянган төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй технологийн шаардлага хангахгүй, ашиглах хугацаа нь дууссан 17,260.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 төрлийн Веб сайтын программ хангамжийг акталж, хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг шуурхай түгээх, хэрэглэгчдийн тоог өсгөх зорилгоор хэрэглэгчдийн гар утсанд суулгах 77,950.0 мянган төгрөгийн аппликейшн худалдан авч хэрэглэгчдэд мэдээлэл түгээн ашиглаж байгаа бөгөөд бусад биет бус хөрөнгөд бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 654.0 мянган төгрөг болж 144.6 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын хөнгөлөлтийн зөрүүнээс шалтгаалжээ.

МОНЦАМЭ агентлагийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 275,189.8 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвөөс санхүүжих хөрөнгийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 127,307.7 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалин, нэмэгдэл цалингийн зардлууд байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага 2020 оны төсвийн төслийг 4,300,273.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,847,224.6 мянган төгрөгөөр бууруулж 2,453,049.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүйгээр хэт өндөр дүнгээр төлөвлөж байгааг харуулж байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх дотоод гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,453,049.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,268,049.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 180,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 5,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,900,513.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 190,316.0 мянган төгрөг, нийт 2,090,829.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,090,829.8 мянган төгрөгийг зарцуулж 18,867.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 362,219.5 мянган төгрөг буюу 85.2 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийг 10,765.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 135,083.2 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 521.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,057.5 мянган төгрөгөөр, төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж зардлыг 212,373.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь дотоод гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа хөтөлбөрийн бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээ арга хэмжээ 135,083.2 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагаа, арга хэмжээ 11,287.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг арга хэмжээ 2,057.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 52,750.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,000.0 мянган төгрөг, нийт 67,750.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөг, улсын маягт хэвлэн бэлтгэх зардалд 3,800.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 15,000.0 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардалд 47,950.0 мянган төгрөг нийт 67,750.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 17 мэдээлэл байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 2, зарлагын 2 гүйлгээний нийт 124,400.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 11,356.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-		-				
Албан шаардлага	1	-	1	-			100.0
Зөвлөмж	3	11,356.1	3	11,356.1			100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>11,356.1</b>	<b>4</b>	<b>11,356.1</b>			<b>100.0</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 54,598.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 52,283.1 мянган төгрөгийн алдааг залруулж 2,315.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тус агентлагийн 2020 оны санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнгийн эхний үлдэгдлийг 47,223.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан,
2. Тавилга, эд хогшлын дансанд бүртгэлтэй байсан 5,060.0 мянган төгрөгийн 6 ширхэг Dell компьютерыг тоног төхөөрөмжийн дансанд шилжүүлэн залруулав.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

МОНЦАМЭ агентлагийн шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 4 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МОНЦАМЭ агентлагийн удирдлагад даалгав.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2,315.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

МОНЦАМЭ агентлагийн 2019, 2020 онд ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу акталсан хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн байдал, акталсан үндсэн хөрөнгийн дүнгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Тус агентлагийн мөнгөн кассын тайлан тооцоог шалгаж үзэхэд кассын бэлэн мөнгөний үлдэгдлийг хуримтлуулан 2020 оны 1 дүгээр сард 3 удаа, 10 дугаар сард 2 удаа, бусад саруудад тус бүр 1 удаа буюу 918.6 - 3,711.3 мянган төгрөгийг Төрийн санд төвлөрүүлж ирсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг зөрчсөн байна.

###### 1.2. Эрсдэл:

Мөнгөн кассын журам зөрчигдөж, бэлэн мөнгийг алдаж үрэгдүүлэх, зүй бусаар зарцуулах.

###### 1.3. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 2. Дотоод хяналттай холбоотой асуудал

###### 2.1. Илрүүлэлт:

МОНЦАМЭ агентлагийн 2012 оны 32 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталж, Дотоод хяналт шалгалтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын баг нь тайлант онд хяналт шалгалтын тусгайлсан төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

Энэ нь тус агентлагийн “Дотоод хяналт шалгалтын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4-д “Дотоод хяналт шалгалтын баг нь ... тухайн жилд хийх хяналт шалгалтын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан Агентлагийн даргын тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллана”, 3.7.1-д “Зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

###### 2.2. Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагаанд оршиж буй зөрчил дутагдал арилахгүй, санхүүгийн тайлан тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тавих удирдлагын дээд болон дунд шатны хяналт алдагдах.

###### 2.3. Өгсөн зөвлөмж:

Агентлагийн “Дотоод хяналт шалгалтын журам”-ын хэрэгжилтийг хангуулж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү, нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг жил бүр тодорхой асуудлаар төлөвлөн хэрэгжүүлж ажиллах.

#### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### 3. Улсын бүртгэлтэй холбоотой асуудал

#### 3.1. Илрүүлэлт:

Тус агентлагийн 1700839 регистрийн дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээ нь 1998 онд Сангийн яамнаас олгосноос хойш шинэчилсэн бүртгэл хийгдээгүй байна.

Энэ нь “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” 2018 оны хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д “төрийн байгууллага, албан газар”, 8 дугаар зүйлийн 8.8.1-д “гэрчилгээ болон тамга, тэмдэг ашиглах боломжгүйгээр элэгдэж хуучирсан, гэмтсэн”, 8.8.3-д “хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн хүрээнд гэрчилгээг дахин авах . . .” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### 3.2. Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, төрийн өмчийн оролцооны хувь хэмжээ, удирдлагын талаарх ерөнхий мэдээллийг нотлох үндсэн баримт тодорхойгүй болох.

#### 3.3. Өгсөн зөвлөмж:

“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” хуулийн дагуу МОНЦАМЭ агентлагийн талаарх холбогдох мэдээллийг бүртгүүлж Улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэх.

#### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### 4. Санхүүгийн програмтай холбоотой асуудал

#### 4.1. Илрүүлэлт:

Тус агентлаг 2010 оноос “Ординат” ХХК-ийн санхүүгийн “Винница” программыг ашиглаж байгаа бөгөөд ашиглалтын дараах шаардлагыг хангахгүй байна. Үүнд:

- Бүх төрлийн тайланг Excel файлд хөрвүүлэхэд эмх цэгцгүй, аккруэл болон мөнгөн суурьт тайлангууд хөрвөдөггүй,
- Цалингийн цэсний хүснэгт ойлгомжгүй,
- Төлбөрийн хүсэлтийн маягт стандартын бус,
- Санхүүгийн тайлангийн СТ-2а , СТ-3а маягт нь бүлгийн ангиллаар задарч харагддаггүй,
- Орлого, зарлагын гүйлгээ бичихэд зарим үсгийн фонд танигддаггүй, харилцахаас кассад бичсэн баримт хэвлэгддэггүй алдаа заадаг,
- Цаашид хөгжүүлэлт хийгдэх боломжгүйгээс програмд “СТАУС” цэс оруулах боломжгүй болсон байна.

#### 4.2. Эрсдэл:

Санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын үйл ажиллагаа доголдож, тооцооллын алдаа үүсэж, удирдлагын дээд болон дунд шатны хяналт алдагдах.

4.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн яамны зөвшөөрөлтэй, ашиглалтын шаардлага хангасан санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжаар шинэчлэл хийж, цахим бүртгэлийн хөтлөлтийг сайжруулах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>МОНЦАМЭ агентлагийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			САГ-2021/302/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>МОНЦАМЭ агентлаг</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус агентлагийн мөнгөн кассын тайлан тооцоог шалгаж үзэхэд кассын бэлэн мөнгөний үлдэгдлийг 2020 оны 1 дүгээр сард 3 удаа, 10 дугаар сард 2 удаа, бусад саруудад тус бүр 1 удаа буюу 918.6 – 3,711.3 мянган төгрөгийг хуримтлуулан Төрийн санд төвлөрүүлж ирсэн байна.	2,315.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
2	МОНЦАМЭ агентлагийн 2012 оны 32 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталж, Дотоод хяналт шалгалтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын баг нь тайлант онд хяналт шалгалтын тусгайлсан төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.		Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
3	Тус агентлагийн 1700839 регистрийн дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээ нь 1998 онд Сангийн яамнаас олгосноос хойш шинэчлэл хийгдээгүй, байгууллагын талаарх мэдээллүүд бичигдээгүй, моралын элэгдэлд орж, цаашид ашиглах боломжгүй болсон байна.		Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
4	Тус агентлаг 2010 оноос “Ординат” ХХК-ийн санхүүгийн “Винница” программыг ашиглаж байгаа бөгөөд ашиглалтын дараах шаардлагыг хангахгүй байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Бүх төрлийн тайланг Excel файлд хөрвүүлэхэд эмх цэгцгүй, акруэл болон мөнгөн суурт тайлангууд хөрвөдөггүй,</li> <li>• Цалингийн цэсийн хүснэгт ойлгомжгүй харагддаг,</li> <li>• Төлбөрийн хүсэлтийн маягт стандартын бус,</li> <li>• Санхүүгийн тайлангийн СТ-2а , СТ-3а маягт нь бүлгийн ангиллаар задарч харагддаггүй,</li> <li>• Орлого, зарлагын гүйлгээ бичихэд зарим үсгийн фонд танигддаггүй, харилцахаас кассад бичсэн баримт хэвлэгддэггүй алдаа заадаг,</li> <li>• Цаашид хөгжүүлэлт хийгдэх боломжгүйгээс “СТАУС” цэс оруулах боломжгүй болсон байна.</li> </ul>		Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа



МОНЦАМЭ агентлагийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Тус агентлагийн шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 4 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.		Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
<b>ДҮН</b>		<b>2,315.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 11/АД160056

Улаанбаатар хот

СЭГ- 0001/302/СТА- ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн МОНЦАМЭ агентлагийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус агентлагийн шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 4 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МОНЦАМЭ агентлагийн дарга Б.Ганчимэг, Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч С.Золзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ДАВААДОРЖ

Г.ЮРА

4006109  
9019120395

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2021\0224auditin 2-R Газар3.Docx

001081000



